



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2010 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 418

Улаанбаатар хот

Г “Улаанбаатар хотын даатгал” ХХК-д Г
дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэхийг
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 153 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг нийт 498 000 000.0 /дөрвөн зуун ерэн найман сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 1 000 000 000.0 /нэг тэрбум/ төгрөгт хүргэж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгчид	Дүрмийн сангийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	“Улаанбаатар сан” ХХК	40 000 000.0	-	40 000 000.0	4,0%
2	Цог овогтой Чойбат	462 000 000.0	498 000 000.0	960 000 000.0	96,0%
	Нийт	502 000 000.0	498 000,000.0	1 000 000 000.0	100,0%

2. Дүрмийн сангийн хэмжээнд орсон өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2011 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Улаанбаатар хотын даатгал” ХХК /М.Энхболд/-д үүрэг болгосугай.

3. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн дүрмийн санг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан “Танан импекс” ХХК-ийн 2010 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансад оруулах өөрчлөлтийг санхүүгийн тайланд тусгаж, холбогдох баримтыг 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг хувь нийлүүлэгч Ц.Чойбатад үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН